МЭДЭЭ · 2026 оны 11-р сарын 11

ЭМГЭНЭЛ



ЭМГЭНЭЛ

НАНЗАДЫН ГАНБАЯР

1953-2026

Монгол Улсын ерөнхий прокурор асан, Ардчилсан Үндсэн хууль тогтоогч, Гавьяат хуульч Нанзадын Ганбаяр таалал төгсөж, бидэнд нөхөж баршгүй гарз тохиолоо.

Н.Ганбаяр нь 1953 онд Улаанбаатар хотод төрж, 1976 онд Зөвлөлт Холбоот Улсын Эрхүү хотын Улсын Их сургуулийг эрх зүйч, улс төрч мэргэжлээр төгссөн.

Тэрээр 1976 онд Улсын дээд шүүхийн зааварлагчаар томилогдон, хөдөлмөрийн гаралгаа эхлүүлж, Улсын дээд шүүхийн гишүүн, Улаанбаатар хотын Шүүхийн дарга бөгөөд Ерөнхий арбитрч, Улсын Бага Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга, Соёлын тэргүүн дэд сайдаар ажиллаж байгаад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1993 онд Улсын ерөнхий прокуророор томилогдон, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх зэрэг дэвтэй, 1999 оныг хүртэл ажилласан билээ.

Н.Ганбаяр 1999 оноос 2021 оныг хүртэл хугацаанд Хууль зүйн сайдын зөвлөх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байсан туршлагатай, нэр хүндтэй хуульч, төрийн эрдэмтэн байсан.

Тэрээр Улсын Бага Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дargaар ажиллахда, Прокурорын байгууллагыг шинэ Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг хэрэжүүлэхэд оролцогч байгууллага болох эрх зүйн үндсийг тавихад онцгойлон зүтгэсэн эрхмүүдийн нэгэн билээ.

Н.Ганбаяр Монгол Улсын ерөнхий прокуророор ажиллах хугацаандаа Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль, 1993 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчин, үйл ажиллагаог шинэчлэх шилжилтийн үеийн прокурорын байгууллагыг удирдаж, өөрчлөлт шинэчлэлийг түүхэн уламжлалтай хослуулан олон ур дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь прокурорыг дүрэмт хувцастай болгосон явдал юм.

Хууль тогтоох, шүүх, хууль зүйн салбарын хөгжил дэвшилд оруулсан түүний хөдөлмөр зүтгэлийг Монгол Улсын төр засгаас өндрөөр үнэлж, Сүхбаатарын одон, Монгол Улсын Гавьяат хуульч цол хүртээж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

Түүний эгэл даруу зан, эелэг дотно, түсч дур төрх, шударга, зарчимч байдал, мэргэжлийн өндөр ур чадвар, Прокурорын байгууллагыг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр нь бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

Талийгаачийн гэр бүл, ур хүүхэд, төрөл төрөгсөд гүн эмгэнэл илэрхийлье.

**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР,
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ТЭЭВЭР, ДҮҮРЭГ,
СУМ ДҮҮРЭГ ПРОКУРОРЫН ГАЗАР**

ЭМГЭНЭЛ



НАНЗАДЫН ГАНБАЯР

1953-2026

Монгол Улсын ерөнхий прокурор асан, Ардчилсан Үндсэн хууль тогтоогч, Гавьяат хуульч Нанзадын Ганбаяр таалал төгсеж, бидэнд нөхөж баршгүй гарз тохиолоо.

Н.Ганбаяр нь 1953 онд Улаанбаатар хотод төрж, 1976 онд Зөвлөлт Холбоот Улсын Эрхүү хотын Улсын Их сургуулийг эрх зүйч, улс төрч мэргэжлээр төгссөн.

Тэрээр 1976 онд Улсын дээд шүүхийн зааварлагчаар томилогдон, хөдөлмөрийн гараагаа эхлүүлж, Улсын дээд шүүхийн гишүүн, Улаанбаатар хотын Шүүхийн дарга бөгөөд Ерөнхий арбитрч, Улсын Бага Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга, Соёлын тэргүүн дэд сайдаар ажиллаж байгаад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1993 онд Улсын ерөнхий прокуророор томилогдон, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх зэрэг дэвтэй, 1999 оныг хүртэл ажилласан билээ.

Н.Ганбаяр 1999 оноос 2021 оныг хүртэл хугацаанд Хууль зүйн сайдын зөвлөх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байсан туршлагатай, нэр хүндтэй хуульч, төрийн зүтгэлтэн байсан.

Тэрээр Улсын Бага Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллахда, Прокурорын байгууллагыг шинэ Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болох эрх зүйн үндсийг тавихад онцгойлон зүтгэсэн эрхмүүдийн нэгэн билээ.

Н.Ганбаяр Монгол Улсын ерөнхий прокуророор ажиллах хугацаандаа Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль, 1993 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчин, үйл ажиллагааг шинэчлэх шилжилтийн үеийн прокурорын байгууллагыг удирдаж, өөрчлөлт шинэчлэлийг түүхэн уламжлалтай хослуулан олон үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь прокурорыг дүрэмт хувцастай болгосон явдал юм.

Хууль тогтоох, шүүх, хууль зүйн салбарын хөгжил дэвшилд оруулсан түүний хөдөлмөр зүтгэлийг Монгол Улсын төр засгаас өндрөөр үнэлж, Сүхбаатарын одон, Монгол Улсын Гавьяат хуульч цол хүртээж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

Түүний эгэл даруу зан, элэгсэг дотно, тусч дүр төрх, шударга, зарчимч байдал, мэргэжлийн өндөр ур чадвар, Прокурорын байгууллагыг хөгжүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр нь бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх болно.

Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөдөд
гүн эмгэнэл илэрхийлье.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР,
АЙМАГ, НИЙСЛЭЛ, ТЭЭВЭР, ДҮҮРЭГ,
СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/452